



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 49

Мандалговь

Үндсэн хөрөнгө данснаас хасах  
санал уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,047,758,000.00 төгрөгийн балансийн үнэтэй, 1,778,274,354.00 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 246,730,779.36 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хичээлийн А байрыг, ашиглалтын хугацаа дуусч, элэгдэлгүй, үлдэх өртөггүй болсон сурагчдын хуучин 2 дотуур байрын барилгуудыг тус тус актлуулж, данснаас хасах саналыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Данснаас хасах үндсэн хөрөнгийг устгах ажилд хяналт тавьж ажиллахыг сумын Өмч хамгаалах байнгын зөвлөл, ГИЦС-ийн захирал (Г.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Т.БАТЖАРГАЛ